



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 16-и
дугаар 4490.

Арвайхээр

Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай тэмцэх ажлыг зохион байгуулах тухай

Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.6, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн “Бэлчээр хамгааллын ажлыг эрчимжүүлэх тухай” 185 дугаар тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн “Үлийн цагаан оготнотой тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх хуваарь батлах тухай” А-76 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтан их хэмжээгээр тархсан Зүүнбаян-Улаан, Өлзийт, Есөнзүйл, Хужирт, Хархорин сумдын 31250 га бэлчээрт энгийн механик биологийн аргаар тэмцэх ажлыг 2021 оны 10 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн 5 хоногийн хугацаанд зохион байгуулсугай.

2. Сумдын бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай тэмцэх талбайн хэмжээ, зардлын хуваарилалтыг хавсралтаар баталсугай.

3. Мэрэгч амьтантай тэмцэх ажилд сумын ажилгүй иргэд, малчид, малчдын бүлэг хоршоог хамруулж тэднийг мэрэгч устгалын гарын авлага, шаардлагатай техник хэрэгслээр хангах, сургалт зохион байгуулах болон цаг агаарын saatlaas бусад тохиолдолд ажил саатахгүй байх бэлтгэл зохион байгуулалтын арга хэмжээг авч, хууль журмын дагуу ажиллахыг холбогдох сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Дээрх ажлыг эхлүүлж, сумын Засаг дарга нартай гэрээ байгуулан ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир), уг ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101040

Аймгийн Засаг даргын 2021 оны 10
дугаар сарын 11-ны өдрийн 11:49
дугаар захирамжийн хавсралт

СҮМДЫН БЭЛЧЭЭРИЙН ХӨНӨӨЛТ МЭРЭГЧ
АМЬТАНТАЙ ТЭМЦЭХ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ,
ЗАРДЛЫН ХУВААРИЛАЛТ

д/д	Сум, байгууллагын нэр	Мэргчтэй тэмцэх талбайн хэмжээ га	Зарцуулах хөрөнгө (мянган төгрөг)	Зарцуулах зориулалт
1	Зүүнбаян-Улаан	6250	9500.0	Оготно устгалд оролцох хүмүүсийн цалин (урамшуулал), шатахууны зардал
2	Есэнзүйл	6250	9500.0	Оготно устгалд оролцох хүмүүсийн цалин (урамшуулал), шатахууны зардал
3	Өлзийт	6250	9500.0	Оготно устгалд оролцох хүмүүсийн цалин (урамшуулал), шатахууны зардал
4	Хужирт	6250	9500.0	Оготно устгалд оролцох хүмүүсийн цалин (урамшуулал), шатахууны зардал
5	Хархорин	6250	9500.0	Оготно устгалд оролцох хүмүүсийн цалин (урамшуулал), шатахууны зардал
6	Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мэргэжлийн хяналтын газар		2500.0	Хяналтын зардал
	Дүн	31250	50000.0	

--оо--